



ХОВД, БУЯНТ ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗӨВЛӨЛ



ХАР НУУР-ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

I үе шат: 2011-2015 он, II үе шат: 2016-2021 он

ӨМНӨТГӨЛ

Ус нь аливаа хөгжил, цэцэглэлт, амьдралын цөм юм. Гэвч сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөгөөр усны нөөцийн хомсдол, бохирдол, гамшиг улам эрчимжих хандлагатай болсон. Тиймээс хүн төрөлхтөн усны нөөцийг арвижуулах, хамгаалах, зүй зохистой ашиглахад чиглэсэн урт хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх болсоны нэг нь усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө юм. Үүний нэгэн адил Монгол Улсын Засгийн газар усны асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч, усны менежментийг сав газарт зохион байгуулахаар ус хэрэглэгч, ашиглагч талууд, төрийн, төрийн бус, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл бүхий сав газрын зөвлөл байгуулж ажиллахыг “Усны тухай” хуульд тусгаж өгсөний дагуу Ховд, Буянт голын сав газрын зөвлөл 2009 онд байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн билээ.

Баруун бүс нутгийн гадаргын усны тэжээлийн 70 гаруй хувийг бүрдүүлдэг мөстөл, мөсөн голын хайлалт ихсэж, хуурайшилт эрчимжиж буй энэ үед Ховд, Буянт голын сав газрын зөвлөл төрийн болон төрийн бус, мэргэжлийн байгууллага, эрдэмтдийн дэмжлэгтэйгээр усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг сав газрын түвшинд боловсруулж, нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, хариуцан ажиллах болсон нь тун ач холбогдолтой юм.

Энэхүү усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн орон нутгийн удирдлага, мэргэжилтэн, иргэд, аж ахуйн нэгж буюу бүх ус хэрэглэгч, ашиглагч, шийдвэр гаргагч Та бүхнийг идэвхитэй оролцон хамтран ажиллаж, Баруун бүсийн хөгжил, цэцэглэлтэд өөрсдийн хувь нэмрээ оруулахыг уриалж байна.

Баруун бүсийн Зөвлөлийн дарга
Доктор, профессор Г.Нямдаваа



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

Ховд, Буянт голын сав газрын зөвлөл нь Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Швейцарын Хөгжлийн Агентлагийн Цөлжилтийг сааруулах төсөл болон эрдэмтэн судлаачдын мэргэжлийн болон техникийн дэмжлэг, орон нутгийн удирдлага, ус хэрэглэгч, ашиглагч байгууллага, иргэдийн оролцоотойгоор тус сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулсан болно.

Энэхүү менежментийн төлөвлөгөөг төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, Ховд, Буянт голын сав газрын зөвлөл, ус хэрэглэгч, ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, оролцогч, сонирхогч бүх талууд хамтран хэрэгжүүлнэ.

АГУУЛГА

Өмнөтгөл

Танилцуулга	1
Хар нуур - Ховд голын сав газрын байршил	2
Байгаль орчны төлөв байдал	3
Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ	4
Түүх соёл, зан заншил	4
Сав газрын усны нөөц	5
Усны ашиглалт, хэтийн хандлага	6
Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө	8
Сав газрын зөвлөл	9
Хар нуур – Ховд голын сав газарт тулгамдаж буй үндсэн асуудлууд	10
Асуудал 1: Мөстөлийн хайлалт	11
Асуудал 2: Татмын ойн хэт ашиглалт	13
Асуудал 3: Бэлчээрийн талхидал	13
Асуудал 4: Хөдөө аж ахуйн усны замбараагүй хэрэглээ	14
Асуудал 5: Газрын доорх усны үрэлгэн хэрэглээ	15
Асуудал 6: Усны экосистемийн доройтол	15
Асуудал 7: Усны бохирдол	16
Асуудал 8: Цэвэрлэх байгууламжийн хог, хаягдал ус	17
Асуудал 9: Иргэдийн мэдлэг мэдээлэл хомс	17
Хар нуур-Ховд голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулсан үйл явц	18
Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилтууд	20
1-р үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (2011-2015 он)	21
2-р үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээ (2016-2021 он)	21
Хар нуур-Ховд голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний эхний үе шатыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн (2011-2015 он)	22
Хар нуур-Ховд голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг турших газрууд	23
Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим	24

ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Усны тухай хуулийн 2004 оны шинэчилсэн найруулгаар усны нөөцийн нэгдсэн менежментийн үндсэн зарчмын нэг болох талуудын оролцоог хангасан сав газрын зөвлөл байгуулах, усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах төлөвлөгөө боловсруулах тухай заалтуудыг тус хуулинд нэмж тусгаснаар Монгол оронд усны нөөцийн нэгдсэн менежментийг сав газрын түвшинд зохион байгуулах эрхзүйн орчин бүрдсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны тушаалаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийг 29 усны сав газарт хувааж, усны нөөцийн нэгдсэн менежментийг бий болгоход төрөөс анхаарч ажиллаж байна.

2010 онд батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Ус” үндэсний хөтөлбөр зэрэг төрөөс баримталж буй бодлогын баримт бичгүүдэд усны зохистой хэрэглээ, хамгааллыг сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх замаар бий болгох талаар илүү тодорхой зааж өгчээ.



Зураг 1. Монгол орны 29 усны сав газар

Энэхүү бодлогын хэрэгжилтийг дэмжих зорилгоор Монгол улсад анх удаа усны нөөцийн нэгдсэн менежментийг Хар нуур-Ховд голын сав газарт нэвтрүүлэх ажлыг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар Усны газартай хамтран зохион байгуулсан юм.

Хар нуур-Ховд голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө 2 үе шат дамжин хэрэгжих бөгөөд 2010 оны 9 сард БОАЖ-ын Сайдын тушаалаар албан ёсоор батлагдсан.


ХАР НУУР - ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН БАЙРШИЛ

Хар нуур-Ховд голын сав газар нь Монгол орны баруун хязгаарт орших Төв Азийн гадагш урсацгүй ай савд хамаарах Их нууруудын хотгорын дэд сав газар юм.

Тус сав газар нь манай орны баруун нутагт орших мөнх цас, мөсөн оргил бүхий өндөр уулс, гүн өргөн хавцал хөндий, ой, ойт хээр, тал хээр, говь цөлийн бүс, олон арван гол горхи, нуур, ус намгархаг газруудаас цогцлон бүрдсэн Монголд төдийгүй дэлхийд ховор өвөрмөц нутаг юм.

Хар нуур-Ховд голын сав газар нь баруун талаараа Монгол Алтайн нуруу, хойт талаараа Сийлхэм, Чихачевийн нуруу, Их Түргэн уул, Мөнгөн тайга уул, зүүн талаараа Хархираа, Түргэний уулс, Бураат, Алтан Хөхий уулс, улмаар Их нууруудын хотгорын ёроол, өмнө талаараа Сутай хайрхан, Дарвийн нуруу, Хүйсийн говиор хүрээлэгдэн 86120.8 км² нутаг дэвсгэрийг хамран оршино.


Энэ сав газрыг усзүйн сүлжээгээр Ховд голын сав, Буянт голын сав, Хар-Ус, Дөргөн нуурын өмнөд сав гэж усны балансын гурван нэгжид хуваасан байна. Ховд гол 50149.2 км², Буянт гол 8393.5 км², Хар-Ус, Дөргөн нуурын өмнөд сав 27578.2 км² тус тус талбайг хамардаг.



Зураг 2. Хар нуур-Ховд голын сав газар




БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ



Зураг 3. Хар нуур-Ховд голын сав газрын экосистемүүд

Хар нуур-Ховд голын сав газарт монгол орны мөсөн голуудын 96% оршдог төдийгүй хуурайвтар цөл, говийн нөлөөнд ихээхэн автагдсан өндөр уулын өвөрмөц уур амьсгал бүхий эмзэг экосистемүүд, Хотон, Хурган, Даян зэрэг мөстлөгийн гаралтай цэнгэг, хүйтэн устай том, жижиг нуурууд, “Олон улсын ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчныг хамгаалах тухай” конвенцийн хавсралтад бүртгэгдсэн Хар-Ус, Хар, Дөргөн нуурууд, түүний эрэг, зэгс бүхий ус намгархаг газар зэрэг сав газрын хэмжээнд хамгаалах шаардлагатай олон экосистемүүд бий.


Өвөрмөц экосистемүүд цогцолсон энэхүү сав газарт унаган амьтан, ургамлын зүйлүүд элбэг, улаан ном, үндэсний болон олон улсын ховор ургамал, амьтдын жагсаалтад орсон зүйлс их байгаа нь энэ нутгийн экосистемийг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах шаардлагатайг сануулж байна. Тухайлбал, ховордсон аргаль хонь, янгир ямаа, цоохор ирвэс, зэгсний гахай зэрэг том хөхтөн амьтад, мөн мөлхөгчдийн 3 салбар унаган зүйл (энд бүртгэгдсэн нийт зүйлийн 50%), цохны 12 унаган зүйл, 4 салбар унаган зүйл, загасны 3 унаган зүйл байна.



ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН СҮЛЖЭЭ

Сав газрын нийт 2011,6 мян. га талбай бүхий газар нутаг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдаж байна. Тухайлбал энэ сав газарт Хөх Сэрхийн нурууны дархан цаазат газар, Алтай таван богд, Сийлхэмийн нуруу, Цамбагарав, Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газар, Манхан, Дэвэлийн арлын байгалийн нөөц газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газар нутаг бүтнээрээ, Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын уулын дархан цаазат газрын Бөхмөрөн сумын нутагт харъяалагдах хэсэг болон Гоожуурын хүрхрээ орчмын газар нутаг багтана.

Өнөөгийн байдлаар сав газар дахь улсын тусгай хамгаалалттай нийт газар нутгийн 4.3 хувь буюу 86,7 мян. га талбай нь дархан цаазат газрын, 91.3 хувь буюу 1835,8 мян. га талбай нь байгалийн цогцолборт газрын, 4.4 хувь буюу 89,0 мян. га талбай нь байгалийн нөөц газрын ангилалд тус тус хамаарагдаж байна.



Зураг 4. Хар нуур-Ховд голын сав газар дахь тусгай хамгаалалттай газар нутгууд

ТҮҮХ СОЁЛ, ЗАН ЗАНШИЛ

ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛУУД

Хар нуур-Ховд голын сав газар нь хадны бичээс, сүг зураг, хүн чулуун хөшөө, буган хөшөө, булш, хиргисүүрийн цогцолбор, хэрмийн туурь зэрэг түүх, соёлын дурсгалаар нэн баян билээ. Тухайлбал, хүн төрөлхтний үүсэл хөгжлийн өлгий нутаг хэмээгдэх Манхан сумын нутаг дахь Хойд Цэнхэрийн агуй, түүний зосон зургууд, Тахилт, Тарвагатайн Хүннүгийн булш, Ишгэн толгойн болон Нүхэн өтгийн хадны сүг зураг, Баянтүмбийн булш, чулуун зэвсгийн суурингууд, хүн чулуун хөшөө, чулуун зэвсгийн үе, хүрэл, төмөр зэвсгийн үе, Монголын анхны төрт улс болох Хүннүгийн үеийн түүхтэй холбоотой түүхийн дурсгалууд бий.

Эртний хүмүүсийн соёл иргэншлийн нэгэн гайхамшигт бүтээл болох хад, чулуун дээр улаан зосоор зурсан сүг зургууд ба хаданд сийлж зурсан ан амьтан, хүний дүрс бүхий сүг зургуудаас гадна элдэв тамга, тэмдэг, үсэг зурлага бүхий хад чулуу, чулуун хөшөө Алтайн нуруунд элбэг тохиолдоно.

УГСААТАН, УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШИЛ

Хар нуур-Ховд голын сав газарт хамрагдах Ховд, Увс, Баян-Өлгий аймаг нь олон үндэстэн, ястны өлгий нутаг гэдгээрээ Монгол орны бусад аймгуудаас ялгаатай бөгөөд энэ нутагт гарал үүсэл, шашин шүтлэг, хэл, ахуйн соёлын хувьд ялгаатай Монгол, Казах, Тува үндэстэн, мөн Захчин, Урианхай, Мянгад, Өөлд, Дөрвөд зэрэг Монгол үндэстний бага ястнууд эрт дээр үеэс өнөөг хүртэл өөр өөрсдийн аж ахуйг эрхлэн эвтэй найртай амьдарсаар ирсэн.

Усны нөөцийн нэгдсэн менежмент (УННМ) гэдэг ойлголт нь манай орны тухайд харьцангуй шинэ ойлголт мэт боловч эртнээс нааш нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн уламжлалт ахуй, нийгмийн харилцаанд байсаар ирсэн юм. Энэ ч утгаараа усыг дээдлэх, шүтэх, хамгаалах ёс заншилтайн дээр нэг голынхон, нэг нутаг усныхан гэх найрсаг харилцаа өнөө бидэнд уламжлагдан ирсэн билээ.



САВ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦ


ГАДАРГЫН УС

Монгол Алтайн нурууны араас эх авах Цагаан Ховд гол, Хар Ховд гол хоорондоо холбоотой Хотон, Хурган нуурт цутгаж гарснаас эхлэн Ховд гол хэмээн нэрлэгдэнэ. Сав газрын дээд, дунд хэсэг өндөр уулсын дундуур, зөвхөн адаг 90 км хэсэг нь Их нууруудын хотгорын тэгш талаар урсана. Ховд голын нийт урт 596 км юм. Ховд голд Толбо, Даян, Хотон, Хурган, Ачит зэрэг нуур илүүдэл усаа юүлэхийн хамт өндөр уулсын хур цас мөстөл, мөсөн голын усаар тэтгэгдэх тул урсац 6-7 дугаар сард хамгийн ихдээ хүрч гидрограф нь ихэвчлэн ганц оройтой байна (Зураг 5).


Буянт гол нь Хөх Сэрхий нурууны салбар уулс болох Тахилт уулнаас далайн түвшнээс дээш 3400 м орчим өндрөөс эх авч нийт 8393.5 км² талбайгаас усжих ба голын нийт урт 171.8 км болно. Ганц модны гол, Чихэртэй, Рашаант зэрэг том жижиг 20 шахам гаруй цутгал голууд Буянт голын усыг сэлбэнэ.

Хар нуур-Ховд голын савд Монгол орны нийт мөстлийн талбайн 83.3 хувь буюу 347.4 км² талбайтай мөстөл, мөсөн гол нийт 38 уулсад тархан оршино (Зураг 6).

Энэ сав газрын гол мөрний тэжээлд мөстөл, мөсөн голын усны тэжээл зонхилох нөлөө үзүүлэх учир гол мөрний усны төвшин хавраас эхлэн нэмэгдэж, түүн дээр зуны хур борооны үер давхцаж нэгэн их устай үе хавар-зуны турш ажиглагдана. Иймээс Ховд голын сав газрын гол мөрөн хавар-зуны шар усны үертэй байх усны горимтой.



Зураг 5. Хар нуур-Ховд голын сав газрын гадаргын усны сүлжээ




Зураг 6. Хар нуур-Ховд голын сав газар дахь мөстөл, мөсөн голын тархац

ГАЗАР ДООРХ УС

Газар доорх усны тархац нэн жигд бус, нөөц нь хязгаарлагдмал бөгөөд голын хөндий, бэлчир, садраа адаг, нууруудын болон уулс хоорондын хотгорт хуримтлагдана.

УСНЫ АШИГЛАЛТ, ХЭТИЙН ХАНДЛАГА

Хар нуур-Ховд голын сав газар нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн нийт 29 сумын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг хамрах бөгөөд энэ нутагт амьдрах иргэдийн унд ахуй, газар тариалан, мал аж ахуй, эрчим хүч, бэлчээр, хотын ногоон байгууламж, жижиг дунд үйлдвэрийн салбарын усны эх үүсвэр болдог.



Зураг 7. Хар нуур-Ховд голын сав газар ба засаг захиргааны нэгж

Ховд голын сав газрын нэг жилийн усны нийт хэрэглээ, хандлага:

2008 онд	153.6 сая м ³ /жил
2015 онд	273.6 сая м ³ /жил
2021 онд	373.2 сая м ³ /жил

Ховд голын усны нөөц 2365 сая м³/жил, 95 хувийн хангамшилтай бага устай жилд 1561 сая м³/жил ба 2008-2021 онуудын усны нийт хэрэгцээ, хандлагатай харьцуулахад усны нөөц хүрэлцээтэй байхыг харуулж байна. Гэхдээ уур амьсгалын өөрчлөлтөөс ууршилт эрс нэмэгдэх төлөвтэй байгаа тул түүнээс усны нөөц, горимд учруулах нөлөөллийг нарийвчлан үнэлэх шаардлагатай.

Ховд голын савд газар доорх усны нөөц 786.1 сая м³, хүн амын унд, ахуй ба үйлдвэр үйлчилгээний хэрэгцээнд 2008 онд 4.4 сая м³, 2015 онд 4.9 сая м³, 2021 онд 5.3 сая м³ усыг хэрэглэх, энэ нь уг нөөцийн 0.57-0.67 хувийг эзэлж байгаа нь усны нөөц хангалттай байхыг харуулж байна.

Буянт голын сав газар дахь усны нийт хэрэглээ, хандлага:

2008 онд	126.4 сая м ³ /жил
2015 онд	126.9 сая м ³ /жил
2021 онд	144.6 сая м ³ /жил

Буянт голын усны нөөц 178.8 сая м³/жил, 95 хувийн хангамшилтай бага устай жилд 111.6 сая м³/жил тус тус байгаа нь дээрх усны нийт хэрэглээ, хандлагатай харьцуулахад усны нөөц хүрэлцээгүй байгааг харуулж байна. Энэ голын урсацаар 2008, 2015 оны усны хэрэгцээний 96.9-97.6 хувь буюу бараг бүх усыг ашиглах төлөвтэй, 2021 оны үед ашиглахаар төлөвлөсөн усны хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Буянт голын усыг зохистой ашиглах замаар ус хэрэглээг багасгах, экосистемийг тэтгэхүйц бага урсацыг голд үлдээх арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Буянт голын сав газрын газар доорх усны нөөц 138.8 сая м³ гэж тодорхойлсноос хүн амын ахуйн ба үйлдвэр үйлчилгээний хэрэгцээнд 2008 онд 3.4 сая м³/жил, 2015 онд 3.8 сая м³/жил, 2021 онд 4.1 сая м³/жил усыг хэрэглэх, энэ нь газар доорх усны нөөцийн 2.4-2.9 хувийг эзэлж байгаа нь энэ нөөц боломжийн түвшинд байхыг харуулж байна.

Хар-Ус, Дөргөн нуурын өмнөд сав 1123 сая м³/жил усны нөөцтэй ба 95 хувийн хангамшилтай жилд 703.2 сая м³ устай байна. Дөргөний усан цахилгаан станцын усан сангийн талбайгаас уурших усны хэмжээгээр Хар-Ус нуурын ууршилт нэмэгдсэн. Улмаар Чонохарайх голын норм урсац 32.6 м³/с болж 1.15 м³/с-ээр хорогдсон байна. Гадаргын усны сүлжээ туйлын жигд бус тархацтай тул дээр дурдсан голоос бусад савд газар доорх усыг хэрэглэнэ. Энэ сав газрын усны нийт ашиглалтыг дараах байдлаар төлөвлөжээ. Үүнд:


2008 онд	31.7 сая м ³ /жил
2015 онд	49.4 сая м ³ /жил
2021 онд	51.4 сая м ³ /жил

Газар доорх усны нөөц энэ савд 423.3 сая м³ гэж тодорхойлсноос хүн ам, ахуйн ба үйлдвэр үйлчилгээний усны хэрэгцээнд 2008 онд 0.3 сая м³, 2015 онд 3.1 сая м³, 2021 онд 0.33 сая м³ усыг хэрэглэхээр байгаа нь усны нөөц боломжийн түвшинд байна.



САВ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Цэнгэг усны нөөц, найрлага тухайн бүс нутгийн уур амьсгал, геологийн тогтоц, физик газарзүйн нөхцөлөөс хамаарч жигд бус байна. Жилээс жилд өсөн нэмэгдэх усны хэрэгцээг бүрэлдэн тогтох усны нөөц хязгаарлах тул тухайн сав газрын нийт усны нөөц, түүний сэргэх чадамжид тулгуурлан нийгэм, эдийн засгийн салбаруудыг хөгжүүлэх, байгаль орчинг хамгаалах замаар хойч үеийнхээ ирээдүйг баталгаажуулах боломжтой (Зураг 8).



Зураг 8. Усны нөөц, түүний тогтвортой ашиглалт

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого тухайн усны сав газрын байгаль орчны талаарх бодлоготой уялдан усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөгөөр дамжин хэрэгжих учиртай.

Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг тухайн сав газрын байгаль орчин, нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, өнөөгийн тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга хэмжээ, зорилго, зорилтыг тодорхойлох, тэдгээрийн ач холбогдлыг эрэмбэлэх зэргээр тодорхой үе шаттайгаар боловсруулна.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ, мониторинг хийж, стратегийн зорилго, бодлогод өөрчлөлт оруулах зэргээр усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний боловсруулалт цаашид тойрог хэлбэрээр явдаг (Зураг 9).




Эх сурвалж: Дэлхийн усны түншлэлийн гарын авлага, 2009 (Global water partnership)
Зураг 9. Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний үйл ажиллагаа

Дээрх арга замаар монгол орон анх удаа Хар нуур-Ховд голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулсан юм.

САВ ГАЗРЫН ЗӨВЛӨЛ

Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, “Усны тухай” хууль, “Ус” үндэсний хөтөлбөр зэрэг төрөөс усны талаар баримталж буй бодлогын хэрэгжилтийг сав газрын түвшинд орон нутагт хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр Ховд, Буянт голын сав газрын зөвлөл 2009 оны 03 дугаар сарын 17-нд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 59 тоот тушаалаар байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Монгол орны усны сав газрыг батлах тухай” 2009 оны 332 тоот тушаалаар Ховд, Буянт голын сав газруудыг “Хар нуур-Ховд” усны сав газарт нэгтгэсэн юм. Иймээс Ховд, Буянт голын сав газрын зөвлөлүүд Хар нуур-Ховд голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хамтран боловсруулсан.

Тус сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор аймаг, сумдын удирдлага, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



ХАР НУУР – ХОВД ГОЛЫН САВ ГАЗАРТ ТУЛГАМДАЖ БУЙ ҮНДСЭН АСУУДЛУУД

САВ ГАЗРЫН ХЭМЖЭЭНД ДАРААХ ҮНДСЭН АСУУДЛУУД ТУЛГАРААД БАЙНА

1 Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас голын эх үүсвэр болох **мөстөл хайлж, хуурайшиж** байна.

2 Ховд, Буянт **голын дагуух бургасан ойн хэт ашиглалтын** улмаас олон зүйлийн ургамал, амьтны амьдрах орчин үгүй болж, гадаргын болон газар доорх усны нөөцөд ноцтой нөлөөлөхөд хүрсэн.

3 Сав газрын хэмжээнд **бэлчээр талхигдаж**, малын хөлөөр булаг шандны эх ундарга дарагдах, хуурайшилт цөлжилтийг улам эрчимжүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлэх болсон.

4 Сав газарт үйлдвэрийн усны хэрэглээ бага хэдий ч **голын голдирол өөрчлөх замаар тухайн голын экологийн урсацыг үлдээлгүй хотын ногоон байгууламж, газар тариалан, хадланд усыг замбраагүй хэрэглэсэнээр** томоохон цутгал голуудын усны түвшин багасч, Ховд, Буянт гол Хар-Ус нуурт хүрч цутгахаа больсон.

5 Ховд, Баян-Өлгий хотуудын ус хангамжид **газрын доорх усыг хэт үрэлгэн ашигладаг.**

6 Дөргөний усан цахилгаан станцын үйл ажиллагааны улмаас Чонохарайх голын усны горим өөрчлөгдөн, Хар, Дөргөн нуур, Тээлийн голын **экосистем доройтох** болсон.

7 Сум суурин орчимд голын эрүүл ахуйн **бүсэд хатуу хог хаягдал хаях, мал бэлчээх, машин техник угаах** гэх мэт хүний ухамсаргүй үйлдлээр гол ус бохирдож байна.

8 Ховд, Өлгий хотын цэвэрлэх байгууламжийн техник, технологи хуучирч, түүний бохир ус, лаг гадаргын усны **бохирдлын эх үүсвэр** болж байна.


9 Сав газрын ус, ой болон бусад **байгалийн нөөцийн зүй зохистой ашиглалт, хамгаалалтад талуудын хамтын ажиллагаа, оролцооны тухай иргэдийн мэдлэг мэдээлэл хомс** учир байгаль хамгаалахад идэвхтэй оролцдоггүй.

АСУУДАЛ 1:


МӨСТӨЛИЙН ХАЙЛАЛТ

Хар нуур-Ховд голын сав газар Төв Азийн төвд буюу эх газрын гүнд орших хийгээд далайн төвшнээс дээш ихээхэн өргөгдсөн байгалийн бүс бүслүүрийн онцлогтой уялдан эх газрын эрс тэс, сэрүүн, хуурай уур амьсгалын нөхцөл энд бүрэлдэн тогтоно.

Агаарын температурын бүслэг байдал Алтай нуруу, түүний салбар уулсын нөлөөгөөр энэ бүс нутагт алдагддаг. Жилийн дундаж агаарын температур өндөр уулсаар (Түргэн уул, Сийлхэмийн нуруу, Алтай Таван богд, Цамбагарав, Хөх Сэрхийн нуруу, Мөнхайрхан уул) $-2...-8^{\circ}\text{C}$, нам дор газарт $2-6^{\circ}\text{C}$ байна.



Зураг 10. Жилийн дундаж температурын газар зүйн тархалт





Зураг 11. Жилийн дундаж хур тунадасны орон зайн тархац

Хур тунадас нь голдуу уулзүйн нөлөөгөөр үүсэх учраас хоногийн хамгийн их хур тунадасны бага нь Ховдод 37.8 мм, их нь Улаангомд 102.3 мм тус тус хүрнэ.

Энэ сав газарт сүүлийн 69 жилд агаарын жилийн дундаж температур 2.1°C , харин өвлийн улиралд хамгийн эрчимтэй 3.7°C дулаарчээ. 1990-ээд оноос хойш дулааралт эрчимтэй явагдаж байгаа ба олон жилийн дунджаас дулаан жилүүд ихэнхдээ үргэлжилсэн бөгөөд хамгийн дулаан жил 2007 он байжээ (Зураг 12а).

Энэ сав газар өндөр өргөрөгт, эх газрын гүнд, далайн түвшнээс дээш харьцангуй өндөр оршдог онцлогтой учраас Монгол орны бусад бүс нутгийнхаас илүү эрчимтэй дулааралт энд явагдаж байна. Харин хур тунадас бараг өөрчлөлтгүй, 0.4 мм орчим буюу нэн бага ихсэлт ажиглагдаж байна (Зураг 12б).



Зураг 12. Жилийн а) дундаж агаарын температур, б) хур тунадасны нийлбэрийн олон жилийн явц (олон жилийн дунджийг шулуунаар үзүүлэв)

Өвлийн хүйтэн зөөлөрч хур тунадас ахиу орох, харин зуны халуун эрчимжиж, хур тунадас буурах нь нэгэнтээ эхэлсэн хуурайшилтыг улам бүр эрчимжүүлэн, мөсөн гол, мөстөл, цэвдэг хайлах, хуурайшилт, цөлжилт ихсэх, хур тунадасны горим өөрчлөгдөх, ургамлын ургалтад дарамт үзүүлэх зэргээр байгальд төдийгүй нийгэм-эдийн засгийн салбаруудад сөрөг үр дагаврыг дагуулах болсон.

Нэгэнт мөстөл хайлж, улмаар хуурай хээр, говь, цөлийн бүсэд ууршилт ихсэн, нуурууд, усан сангийн гадаргаас ууршилтаар ус буцалтгүй алдагдах учраас усны нөөцийг ууршилт хамгийн бага байх өндөр уулын бүсэд хуримтлуулахын зэрэгцээ, үр ашиггүй усан сангуудыг байгуулж усны алдагдлыг улам нэмэгдүүлэхгүй байхыг байгаль, түүний өөрчлөлт бидэнд сануулсаар байна.



АСУУДАЛ 2:

ТАТМЫН ОЙН ХЭТ АШИГЛАЛТ

Ховд, Буянт голын дагуух бургасан ой хэт ашиглалтын улмаас устах аюулд орсон байна. Энэ ой уствал олон зүйлийн ургамал, амьтны амьдрах орчин үгүй болох ба гадаргын болон газар доорх усны нөөцөд ноцтой нөлөөлж хуурайших аюултай.



АСУУДАЛ 3:

БЭЛЧЭЭРИЙН ТАЛХИГДАЛ

Мал аж ахуй нь тус сав газрын эдийн засгийн гол салбар байсаар ирсэн бөгөөд сав газрын хэмжээгээр 8.1 сая га бэлчээрт 4.4 сая хонин толгойтой тэнцэх мал бэлчиж байна. Мөн энд 67.7 тэрбум төгрөгийн мал аж ахуйн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж байна.

Сав газрын мал сүргийн тоо толгой жил дараалан өсөж, сүргийн бүтцэд ямааны эзлэх хувь нэмэгдэж ирсэн нь бэлчээрийн даацын хэтрэлтэд хүргэж, улмаар алс хэтэд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь өсөн нэмэгдэх болсон. Тухайлбал, Ховд аймгийн малын тоо 2002 онд 2052.9 сая хонин толгой байсан бол 2008 онд 3474.2 сая болж 1.7 дахин өсчээ.




АСУУДАЛ 4:

ХӨДӨӨ АЖ АХУЙН УСНЫ ЗАМБАРААГҮЙ ХЭРЭГЛЭЭ

Сүүлийн жилүүдэд энэ сав газарт хур тунадас бага, гантай байгаагаас байгалийн хадлан, бэлчээрийн гарц муудаж, хадлан авах, мал бэлчээрлэхэд ихээхэн бэрхшээлтэй болжээ. Иймээс малчид бэлчээрийн талбайг энгийн аргаар услах нь түгээмэл юм.

1970-1980- аад онуудад Ховд, Буянт болон бусад голоос ус авах инженерийн хийцтэй 2995 га талбай бүхий 15 услалтын систем байгуулсан байжээ. Эдгээр системүүд эвдэрч, бороожуулах болон бусад тоног төхөөрөмж нь тоногдсон тул ихэнхи нь ажиллахгүй байна. Эдгээрийн дотроос 12 услалтын системийн толгойн барилга, гол сувгийг ашиглан талбайд ус халиах аргаар малын тэжээл, төмс, хүнсний ногоо тариалж, ашиглаж байна. Тухайлбал, Буянт голын адагт тариаланчид голын гольдролыг өөрчлөн газар тариалан, хадлангийн талбайг замбараагүй усалсанаар Буянт гол Хар-Ус нуур болон Ховд голд цутгахаа больсон.

Ховд аймгийн Буянт голын сав газрын усалгаатай талбайн байршил, эзэмшлийн зураг



Мөн, Цагаан голын үлдсэн усыг хааж, энгийн халиах замаар хадлангийн томоохон талбайг усалсанаар Ховд голд хүрэлгүй хөрсөнд шингэдэг болж байна. Үүний улмаас энэ голын дагуух ул хөрсний усны төвшин нэмэгдэж намагжин, голын адаг хавийн 4000 гаруй га талбайг ашиглах боломжгүй болжээ.



АСУУДАЛ 5:

ГАЗРЫН ДООРХ УСНЫ ҮРЭЛГЭН ХЭРЭГЛЭЭ

Өлгий, Ховд хотын хүн ам, аж ахуй нэгж газар доорх усыг өдөр тутам хэрэглэдэг. Одоогоор хотын ус хангамжийн эх үүсвэрийн нөөц хүрэлцээтэй байгаа хэдий ч 1 хүний хоногийн хэрэглээ 500 л/хоног буюу бусад хотуудаас 2 дахин их байгаа нь усыг шугам хоолойны алдагдалгүйгээр хэрэглэгчид хүргэх, хэрэглэгчдийг тоолууржуулах, ариг гамтай хэрэглээнд оруулах шаардлагатайг сануулсаар байна.



АСУУДАЛ 6:



УСНЫ ЭКОСИСТЕМИЙН ДОРЙТОЛ

Усны үрэлгэн ашиглалтын улмаас Ховд, Буянт голын ус багасаж, Хар-Ус нуур, Чонохарайх гол, Хар, Дөргөн нуур, Тээлийн голд илт сөргөөр нөлөөлж, эдгээр гол, нуурын усны экосистем доройтож байна.

Голууд нь усны нөөцийн зэрэгцээ энергийн чухал нөөц болсоор ирсэн. Том хэмжээний усан сан үүссэнээр боомтын дээд хэсэгт усан сан үүсч, урсгал усанд зохицсон усны амьтад хэдэн километр устаж алга болдог. Загасны үржил, ялангуяа, голд түрсээ шахдаг загасны үржил хөгжилд боомт ихээхэн хор холбогдолтой байдаг.

Боомтоос дооших голын хэсгийн урсац ямар нэг хэмжээгээр багасч байгалийн зохицуулга нь алдагддаг. Урсац буурах нь аажим тасралтгүй явагдсаар урсгал үгүй болох нь ч бий.


Цаашид нүүдлийн шувуу, загасны үржил, нүүдэлд онцгой ач холбогдолтой Сэжигтийн хавцал, Чонохарайх, Ховд голын дагуух ан амьтдыг хамгаалахад онцгой ач холбогдолтой. Дэвэл зэрэг арал хэлбэрийн экосистемийг улсын болон орон нутгийн хамгаалалтад авах шаардлагатай юм.



АСУУДАЛ 7:

УСНЫ БОХИРДОЛ

Голын савд хуримтлагдсан элдэв хог хаягдал, хаврын шар ус, зуны хур борооны үерийн үед угаагдаж, зарим жилд байгалийн гамшиг болж, ихээхэн мал хорогдон, малын сэг зэм ихэссэнтэй холбоотойгоор бохирдлын үзүүлэлтүүд хүлцэх агууламжийг давах тохиолдол ажиглагдаж байжээ.



АСУУДАЛ 8:

ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ХОГ, ХАЯГДАЛ УС

Ховд хотын цэвэрлэх байгууламж нь хоногт 4800 м³ ус зайлуулан, жилд нэг шүүлтүүрийн тагтнаас 40 тн лаг хусаж байгаль дээр ил задгай хаяж байна.

Тус байгууламж нь бохир уснаас үүссэн лаг наангийг горимын дагуу устгаж ариутгадаггүй, хязгаарлалтын бүсээс 300 метрийн зайд ил задгай талбайд хаяснаар салхи шуурга, цас, бороо орсон үед лаг хөрсний угаагдлаар урсах, ил хаясан лаг ууршиж агаар дахь хорт бодисын хэмжээг ихэсгэх нь ойр орчмын оршин суугчдын эрүүл ахуй, ундны усанд сөрөг нөлөөллүүдийг үзүүлж байна.



АСУУДАЛ 9:


ИРГЭДИЙН МЭДЛЭГ МЭДЭЭЛЭЛ ХОМС

Сав газрын ус, ой болон бусад байгалийн нөөцийн зүй зохистой ашиглалт, хамгаалалтад талуудын хамтын ажиллагаа, оролцооны тухай иргэдийн мэдлэг мэдээлэл хомс учир байгаль хамгаалахад идэвхтэй оролцдоггүй.

ХАР НУУР-ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН ҮЙЛ ЯВЦ

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас Нидерланд улсын DHV компанийн зөвлөх, усны салбарын төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэд, мэргэжилтнүүдтэй хамтран “Монгол орны сав газрын нэгдсэн менежментийн төлөвлөгөөний ерөнхий бүтэц, агуулга”-ыг тодорхойлж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газартай зөвшилцөн тогтсоны үр дүнд дараах үе шаттайгаар сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

1 Монгол орны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний ерөнхий бүтэц, агуулгын хүрээнд 2009 онд суурь судалгааны ажлыг сав газрын хэмжээнд зохион байгуулсан (зураг 13).



Зураг 13. Суурь судалгааны багийн бүтэц, зохион байгуулалт

2 Ховд, Буянт голын сав газрын зөвлөл 2009 оны 9 дүгээр сард голын сав дагуу танилцах аялал хийж, менежментийн төлөвлөгөөнд тусгах асуудлуудыг тодорхойлов.

3 Сав газрын зөвлөл 2009 оны 12 сард ээлжит хурлаа зохион байгуулж, Хар нуур-Ховд голын сав газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулав.

4 Менежментийн төлөвлөгөөнд тусгах үндсэн асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор аймаг сумдын удирдлага, малчин, хадлан, тариалан эрхлэгч иргэд, төрийн болон төрийн бус байгууллага гэх мэт ус хэрэглэгч, ашиглагч, оролцогч талуудын дунд шат дараалсан хэлэлцүүлгийг голын эх, дунд, адагт зохион байгуулсан.

5 Сав газрын зөвлөл 2010 оны 5 дугаар сард Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн удирдлага, мэргэжлийн байгууллагуудад төлөвлөгөөний төслийг хүргэн санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулж, эцсийн хувилбарыг 6 дугаар сарын 4-нд сав газрын зөвлөлийн ээлжит 3 дугаар хурлаар зөвшилцөн, Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн ИТХ-д хүргүүлсэн.

6 Сав газрын зөвлөлийн ажлын хэсэг үндэсний зөвлөх баг (А.Бакей, Г.Даваа, Д.Доржсүрэн)-тай хамтран Хар нуур-Ховд голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулав.

7 2010 оны 6 дугаар сард дээрх 3 аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар менежментийн төлөвлөгөөг хэлэлцэн, орон нутагт хэрэгжүүлэхээр дэмжсэнээр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 2010 оны 09 сард баталсан.




САВ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Хар нуур-Ховд голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө нь эрхэм зорилгодоо хүрэх 4 стратегийн зорилт, түүнтэй уялдсан 12 үйл ажиллагааны зорилт, 140 үйл ажиллагаа бүхий нийт 39154.2 сая төгрөгний төсөвтэй төлөвлөгөө болсон.

Уг менежментийн төлөвлөгөө нь урт болон богино хугацааны 2 төлөвлөгөөнөөс бүрдэх бөгөөд 2 үе шат дамжин хэрэгжинэ.

Богино хугацааны төлөвлөгөө нь 2011-2015 онд голын эхэн, дунд, адагт хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэгч талуудын хамт тусгасан. Мөн нийт шаардагдах төсвийг улсын, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр болон бусад боломжит эх үүсвэрүүдэд хувиарлан тооцсон нь эдгээр байгууллагуудтай харьцах, тэдний дэмжлэг туслалцааг авахад энэхүү менежментийн төлөвлөгөө гол баримт бичиг болох юм.



1-Р ҮЕ ШАТАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (2011-2015 ОН)

Сав газрын эхэн хэсэг

1. Ойн нөөц, загас, шувуу зэрэг биологийн төрөл зүйлийг хамгаалахад ач холбогдолтой болон голын урсацын 70% бүрдэх Ховд голын эх болох Сагсай, Бага Ойгур, Цагаан голын адаг, Буянт голын эх болох Чихэртэй, Таван салаа, Ганц модны голуудын эхийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах
2. Дэлүүн, Сагсай, Улаан хус, Цэнгэл, сумдад ойжуулах ажлыг нэмэгдүүлж, ой зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах
3. Цэнгэл, Сагсай, Улаанхус, Бөхмөрөн, Дэлүүн, Дуут, Алтанцөгц, Ногооннуур сумдад булаг шандны эхийг сэргээх, хашиж хамгаалах идэвхи санаачлагыг дэмжих, идэвхижүүлэх
4. Хотон, Хурган, Хүйтэн, Тал, Чихэртэй нуурын бэлчээрийг нутгийн малчид, нөхөрлөлийн оролцоотойгоор оновчтой зохион байгуулах, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих
5. Голын эхэн хэсгийн хадлангийн усалгааг хуваарьтай болгох, дэвшилтэт технологи нэвтрүүлэх
6. Сыргалын хоолой, Хотон нуур, Бөхмөрөн голд ус судлалын харуул, олон жилийн цэвдгийн цэвдэг үргэлжилсэн тархацтай бүсэд цэвдгийн хяналт шинжилгээний сүлжээ, Баян-Өлгий аймагт Мөстөл судлалын өртөө байгуулах зэргээр хяналт шинжилгээний сүлжээ мониторингийг сайжруулах
7. Өндөр уулын бүсэд гадаргын усны нөөцийг хуримтлах усан санг байгуулах хайгуул, судалгаа явуулах

Сав газрын дунд хэсэг

8. Ойн нөөц, загас, шувуу зэрэг биологийн төрөл зүйлийг хамгаалахад ач холбогдолтой Чонохарайх, Сажигтэйн хавцал, Ховд, Буянт, Цэнхэрийн голыг орон нутгийн хамгаалалтад авах
9. Өлгий, Ховд хотуудын төвлөрсөн усан хангамжаас ус хэрэглэгч айл өрх, албан байгууллагуудыг бүрэн тоолууржуулах
10. Өлгий, Ховд хот дахь ус цэвэрлэх байгууламжийн техник, технологийг шинэчлэх
11. Ховд, Өлгий хот болон бусад голын дагуу байрлах сум суурингийн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох
12. Голын сав дагуух сум суурин газруудын ойролцоох голуудын хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх, дэглэм мөрдүүлэх
13. Баян-Өлгий аймгийн Алтанцөгц, Ногооннуур, Баяннуур, Бугат, Увс аймгийн Ховд, Өмнөговь, Ховд аймгийн Ховд, Буянт, Жаргалант сумдад ойжуулах ажлыг нэмэгдүүлж, ой зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах
14. Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Ховд, Буянт сум болон Баян-Өлгий аймгийн Баяннуур сумдад булаг шандны эхийг сэргээх, хашиж хамгаалах идэвхи санаачлагыг дэмжих, идэвхижүүлэх

Сав газрын адаг хэсэг

15. Буянтын 2400 га-гийн усалгаатай газар тариалангийн бүсэд инженерийн хийцтэй усалтын систем байгуулан усны шударга хуваарилалт, зохистой хэрэглээг бий болгох
16. Дөргөний усан цахилгаан станцын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тодотгол хийлгэж, сөрөг нөлөөг бууруулах

Голын сав газрын хэмжээнд явуулах нийтлэг арга хэмжээ

17. Малын чанарыг сайжруулах замаар усны нөөц, бэлчээрийн ачааллыг бууруулах
18. Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, уламжлалт зан үйл, хэм хэмжээг шинжлэх ухааны мэдлэг, дэвшилтэт арга технологиор баяжуулж нийт иргэдэд сурталчлан таниулах ажлыг тасралтгүй сав газрын хэмжээнд явуулах

2-Р ҮЕ ШАТАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ (2016-2021 ОН)

Сав газрын эхэн хэсэг

1. Голын урсац бүрэлдэх эх хэсгийн 70 орчим хувь болон биологийн төрөл зүйлийг хамгаалахад ач холбогдолтой газруудыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах
2. Усалгаатай хадлангийн усалгааны сувгуудын толгойн барилгуудыг сэргээж усалгааны шинэлэг технологиудыг нэвтрүүлэх
3. Ууршилт багатай өндөр уулын бүсэд 60-70 шоо км ус хуримтлуулах далан байгуулж урсацын тохируулга хийх
4. Хяналт шинжилгээний сүлжээ байгуулж, цаг агаарт зориудаар нөлөөлөх газрын генераторыг өндөр уулын бүсэд байрлуулах
5. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажлуудыг дэмжих, элсний нүүдлээс хамгаалах зурвас байгуулах

Сав газрын дунд хэсэг

6. Голын сав дагуух хот суурин газрын газар доорх усны үрэлгэн хэрэглээг хязгаарлах, тоолууржуулах
7. Цэвэрлэх байгууламжийн усыг эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлэх
8. Ховд, Өлгий хотын ус хангамжийн шугам сүлжээг сайжруулах
9. Хотын ногоон байгууламжийн усалгааг орчин үеийн дэвшилтэт технологиор бүрэн шинэчлэх
10. Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг дэмжин, иргэдийн модны хэт ашиглалтыг бууруулах

Сав газрын адаг хэсэг

11. Газар тариалангийн бүсэд усалгааны дэвшилтэт технологиудыг бүрэн нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх
12. Дөргөний усан цахилгаан станцын загас өнгөрөөх сувгийг шинэчлэх, сайжруулах ажлыг зохион байгуулах

Сав газрын хэмжээнд явуулах нийтлэг арга хэмжээ

13. Голын сав газрын 5 хүртэлх хувьд ойжуулалт нөхөн сэргээлт хийх
14. Сав газрын хэмжээнд булаг шандны 80 орчим хувийг хашиж хамгаалах
15. Голын сав дагуух бүх сум суурин газруудад эрүүл ахуй, энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх, дэглэм мөрдүүлэх
16. Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, уламжлалт зан үйл, хэм хэмжээг шинжлэх ухааны мэдлэг, дэвшилтэт арга технологиор баяжуулж нийт иргэдэд сурталчлан таниулах ажлыг тасралтгүй явуулах

ХАР НУУР-ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ҮЕ ШАТЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН (2011-2015 ОН)

- Голын урсац бүрэлдэх эхийн 30 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна.
- Цэнгэл, Улаанхус, Сагсай сумдад ойжуулалтыг 200 га-д, нөхөн сэргээлтийг 100 га-гаас доошгүй талбайд хийсэн байна.
- Нутгийн иргэдийн оролцоотой булаг шандны ундаргыг хамгаалах, сэргээх уламжлалыг сэргээж, сав газрын нийт булаг шандны 40 хувийг хашиж хамгаална.
- Дэлүүн, Цэнгэл сумдад хадлангийн усалгааг хуваарьтай ашигладаг болно.
- Усны нөөц, чанарын хяналт шинжилгээний сүлжээний 4-5 харуул байгуулагдана.
- Өндөр уулын бүсэд гадаргын усны нөөцийг хуримтлах усан санг байгуулах боломж бүхий газрууд тодорхой болно.
- Өлгий, Ховд хотын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон айл өрх, албан байгууллагын 50 хувь тоолууржсан байна.
- Өлгий, Ховд хотын цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэлийг эхлүүлнэ.
- Буянтын 2400 га-гийн услалтын систем бүрэн ашиглалтад орж, газар тариалангийн үйлдвэрлэл 2 дахин нэмэгдэнэ.



ХАР НУУР-ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ТУРШИХ ГАЗРУУД

Эхний үе шатанд дараах 3 газарт усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглалтыг бий болгоход чиглэсэн томоохон арга хэмжээг хэрэгжүүлэхээр туссан. Үүнд:

1. ХАР НУУР-ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН

ДЭЭД ХЭСЭГ БОЛОХ БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ

(Буянт голын эх болох Дэлүүн сум ба Ховд голын эх болох Цэнгэл сум, Сагсай, Улаан хус сум) - ойжуулах, булаг шандны эхийг сэргээх, хашиж хамгаалах, голын эх үүсвэрийг хамгаалалтад авах, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хадлангийн усалгааны замбараагүй ашиглалтыг бууруулах



2. САВ ГАЗРЫН ХҮН АМЫН ТӨВЛӨРӨЛ БҮХИЙ

ӨЛГИЙ, ХОВД ХОТОД

- тоолууржуулах, ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр орчин үеийн шаардлага хангасан байгууламжтай болох, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, голын хамгаалалтын бүсийг тогтоож тэмдэгжүүлэх дэглэм мөрдүүлэх



3. ХАР НУУР-ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН ДООД

ХЭСЭГ БОЛОХ ХОВД АЙМАГТ

(Ховд, Буянт голын адаг орчим Мянгад, Ховд, Буянт, Дөргөн сум) - ойжуулах, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, газар тариалангийн усалгааны замбараагүй ашиглалтыг бууруулах



УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЗАРЧИМ

- Энэхүү төлөвлөгөө нь мөрдөгдөх хугацааныхаа туршид сав газрын усны менежментийн үйл ажиллагааны үндсэн хөтөлбөр болно.
- Сав газрын аймаг, сумдын бүх шатны богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, стандарт, дүрэм, журам энэхүү менежментийн төлөвлөгөөтэй нягт уялдаж хийгдэнэ.
- Лобби, манлайлал, түншлэл, зар сурталчилгаа зэрэг арга хэрэгсэл, механизмыг ашиглан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ба сав газрын аймаг, сумдын удирдлага, мэргэжилтэн, ажилтан бүр ажил хэрэгчээр идэвхтэй оролцоно.
- Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд байнга хяналт тавьж ажиллах ба шаардлагатай үед зохих тодотгол хийж, уян хатан байдлаар зохицуулалт хийж болно.





ХОВД, БУЯНТ ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗӨВЛӨЛ

Ховд аймаг Жаргалант сум
Алтай трестийн байр
Утас: 01432-22228
Факс: 01432-22228
Шуудангийн хайрцаг: 203
Вэб сайт: www.khovd-gol.mn
info@khovd-gol.mn



Бидний эрхэм зорилго

Монгол орон зэрлэг ан амьтан, ургамлын өлгий нутаг байж, хүн ард нь байгальтайгаа шүтэлцэн үеийн үед сэтгэл хангалуун амьдрах ирээдүйг бүтээхэд оршино.